



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН  
ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ**

2015 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

**Нэрийн дансны 2014 оны орлогод тооцох хүүгийн  
хэмжээг тогтоох тухай**

Нийгмийн даатгалын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 7 дугаар заалт, Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2015 оны 02 дугаар сарын 03-ний өдрийн хурлын 01 дүгээр тэмдэглэл, Үндэсний статистикийн хорооны 2014 оны 01/1033 дугаар албан тоотоор ирүүлсэн саналыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

Нэг. Даатгуулагчдын тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2014 оны орлогод тооцох жилийн хүүгийн хэмжээг 18.6 хувиар баталсугай.

Хоёр. Нийгмийн даатгалын ерөнхий газар (Ц.Уртнасан)-т ДААЛГАХ нь:

а/ Баталсан хүүгийн хэмжээг үндэслэн даатгуулагчийн тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн дансны 2014 оны орлогод хүү тооцох ажлыг 2015 оны 1 дүгээр улиралд багтаан хэрэгжүүлэх;

б/ Нэрийн дансны мэдээлэх хуудсыг даатгуулагчдад 2015 оны 2 дугаар улиралд багтаан мэдээлэх ажлыг зохион байгуулах.

Гурав. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавихыг Ажлын алба (М.Саранчимэг)-нд даалгасугай.

ДАРГА  С.ЭРДЭНЭ